



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ ХУРАЛДЛАА.



Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар дараах 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилт /2013 он А78/
2. Биеийн тамир спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн /2014 он, А/17/
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөө батлах тухай тогтоолын хэрэгжилт /2014.04.16 А/46/
4. Хүнс ХААЯамнаас хөнгөлөлттэй нөхцлөөр авах бага оврын трактор авах тухай
5. Шинэ Улаангом ОНӨААТҮГ-т Их барилга ХХК-ны оруулсан хөрөнгийн тухай асуудал
6. Орон нутгийн өмчийн асуудал

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН ИРГЭДИЙН ШАГНАЛЫГ ГАРДУУЛАА.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 03-р сарын 16-ны өдрийн 19-р зарлигаар Боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, мал аж ахуй, хувийн хэвшил гэх мэт салбар салбартаа олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөн, хөдөлмөрийн өндөр амжилт гарган аймаг, сум, орон нутгийнхаа хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэдийн хөдөлмөрийг өндрөөр үнэлэн “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 3 хүн, “Алтан гадас одон”-оор 41 хүн, Хөдөлмөрийн хүндэт медалиар 21 хүн, Цэргийн хүндэт медалиар 1 хүнийг тус тус шагнажээ. Шагналыг аймгийн удирдлагууд “Галдан бошгот” хааны хүндэтгэлийн өргөөнд ёслол төгөлдөр гардуулан өглөө.



Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Увс аймагт ажиллаж үеэрээ маршал Ю.Цэдэнбалын хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлсэн бөгөөд үүний дараагаар аймгийн удирдлагууд Ерөнхий сайдад цаг үеийн ажил байдлаа танилцууллаа.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн ажилтны мэдээллийн санд бүртгэгдсэн ажилтан, албан тушаалтанд Сонгуулийн тухай хууль тогтоомжийн талаар сургалт явуулж, гэрчилгээ олгох сургалтыг 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт зохион байгуулж байгаа бөгөөд манай аймгийн байнгын бус сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнуудын мэдээллийн санд бүртгэгдсэн ажилтнуудад зориулан сонгуулийн тухай хуулиар цогц сургалтыг аймгийн “Ойрад” ХДТ болон аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд зохион байгуулж хамрагдсан хүмүүст сертификат гардууллаа.



МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СЕМИНАР БОЛЛОО.

2016 оны 4-р сарын 04-06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Монгол Улсад Нийгмийн Эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн төлөвлөлтийн семинарт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ч.Чимэд, ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ нар оролцсон билээ. “Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх төсөл” гэдэг нь Швейцарын Хөгжлийн Агентлаг, Дэлхийн банкны хамтарсан санхүүжилтээр “Эрүүл мэнд”, “Боловсрол”-ын салбарт хэрэгжих бөгөөд төслийн нийт санхүүжилт нь 3 сая америк доллар бөгөөд төсөл 2015-2019 оны хооронд хэрэгжих ба 10-н аймаг, нийслэлийн 3 дүүрэгт хэрэгжихээр сонгогдсон ба Увс аймаг уг төслийг хэрэгжүүлэх зорилтот бүлгээр сонгогдсон байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ч.САЙХАНБИЛЭГ УВС АЙМАГТ АЖИЛЛАЛАА.

2016 оны 04-р сарын 21-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Зам тээврийн сайд Д.Зоригт, ЗГХЭГ-ын дэд дарга Г.Ганболд, Сангийн яамны газрын дарга С.Наранцогт, ХМОНХА-ны дарга Б.Цэцэгл, АТҮТ-ийн тээврийн газрын дарга Ж.Энхбат, ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нямдаваа, Зам тээврийн яамны АЗТБХЗГ-ын дарга Д.Доржханд, Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн, Ерөнхий сайдын зөвлөх Х.Ержан, Ерөнхий сайдын зөвлөх Р.Булгамаа, Ерөнхий сайдын зөвлөх Б.Батбаатар болон бусад албаны хүмүүс ирсэн Увс аймагт ажиллалаа.



Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Увс аймагт ажиллаж үеэрээ маршал Ю.Цэдэнбалын хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлсэн бөгөөд үүний дараагаар аймгийн удирдлагууд Ерөнхий сайдад цаг үеийн ажил байдлаа танилцууллаа.

Цаашилаад өнгөрсөн онуудад Увс аймагт хийгдсэн томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилтай танилцсан юм.

Мөн “Ойрад” ХДТ-т Увс аймгийн хөдөлмөрч ард иргэдтэй уулзалт, ярилцлага хийн зарим иргэдийн сонирхсон асуултад хариулт өглөө.





"МИНИЙ УВС" АЯН ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

2015 онд Увсчууд "Миний Увс" аянд нэгдэж, түүхт 90 жилийн ойгоороо тохижилт бүтээн байгуулалтын ажил өрнүүлж, нэгэн зорилгын дор нэгдэж, бүтээж чаддаг гэдгээ харуулсан. Тэгвэл шинэ ондоо тус аяныг үргэлжлүүлэн зохион байгуулахаар Аймгийн эдийн засаг нийгэмийг 2016 онд хөгжүүлэх зорилтод тусгасан. "Миний Увс" өнгөрсөн онд иргэдийг хамтарч ажиллаж, амьдрах орчноо тохижуулахыг уриалж байсан бол энэ онд иргэд хамтран хийсэн ажлаа ариглан хамгаалах, орц, гудамжаараа санаа нэгдэн ажиллах, орон нутгаас хэрэгжүүлж буй бодлогын ажлуудыг дэмжихэд иргэдийн оролцоог хангахад чиглэж байна.



Тус аяны хүрээнд аймгийн удирдлага, хэлтэс агентлагийн дарга нар Улаангом сумын 12 багийн бүхий л гудамжинд хуваагдан ажиллаж "Миний Увс" аяны хүрээнд орц, гудамжаараа нэгдэж миний орц, миний гудамж, миний хөрш гэсэн сэтгэлээр хандаж тав тухтай, цэвэр цэмцгэр орчин бүрдүүлж ажиллаж, амьдрахыг уриаллаа. Энэ үеэр иргэд аймаг, сумынхаа удирдлагаас аймаг орон болон багийнхаа түвшинд хийгдсэн болон хийгдэхээр төлөвлөгдөж байгаа ажил арга хэмжээнүүдийн талаар сонирхсон асуултаа асууж харуулт авсан юм.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООД БАЙГУУЛАГДЛАА

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04-р сарын 18-ны өдрийн 21 тоот тогтоолоор аймаг, нийслэлийн сонгуулийн хороодыг байгууллаа. Аймгийн Сонгуулийн хорооны дарга: Г.Болор-Эрдэнэ, Аймгийн ЗДТГ-ын дарга Нарийн бичгийн дарга: Б.Эрдэнэсүрэн, Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Гишүүд: Д.Баяраа, ТЗУХ-ын дарга Б.Ядаамсүрэн, НХХ-ын дарга Ж.Эрдэнэсүрэн, Бүртгэл, статистикийн газрын дарга А.Ариунтуяа, ТЗУХ-ын мэргэжилтэн Н.Энхжаргал, ИТХ-ын мэргэжилтэн Ц.Баттулга, МХГ-ын байцаагч Б.Бүрнээхүү, Цогцолбор 2-р сургуулийн багш нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Мөн Увс аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 04-р сарын 24-ний өдрийн хурлаар Монгол Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумдын сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг баталсан байна.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ЦАХИМ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

04-р сарын 26-ны өдөр Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны удирдлага Аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдтэй цахим хурал хийлээ. Цахим хурлын үеэр сонгуулийн хуулийн



хэрэгжилтийн явц байдал, сонгуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалттай холбоотой асуудлаар мэдээлэл хийж, тулгамдаж буй асуудлын талаар харилцан ярилцлаа.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод ажиллагсад юуны өмнө сонгуулийн хууль тогтоомжийг сайн судлах, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан журам, заавар, загвар, маягт, сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь болон Сонгуулийн Ерөнхий Хорооноос албан бичгээр өгсөн ажлын зөвлөмж, чиглэлийг чанд мөрдөх, тэдгээрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Сонгуулийн Ерөнхий Хорооноос зөвлөв.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНААС СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.

Аймгийн ЗДТГ-ын "Иргэний оролцоо" хуралдааны танхимд Хууль зүйн яамнаас 2016.07.01-ээс хэрэгжиж эхлэх "Захиргааны ерөнхий хууль"-ийн сургалтыг зохион байгууллаа.

Энэ хуулийн зорилго нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршиж байгаа юм.



Сургалтыг Хууль зүйн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Д.Алтантуяа, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн В.Увал нар удирдан явуулж байна.

Сургалтанд аймгийн хууль, хяналтын байгууллагын дарга, албан хаагчид, аймаг сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, тамгын газрын дарга нар, төрийн байгууллагын дарга, эрхлэгч, мэргэжилтнүүд оролцлоо.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал